

САЙНЦАГААН СУМЫН “СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН”-ИЙН 2021 ОНД ОЛГОГДСОН ЗЭЭЛИЙН ЯВЦАД ХЯНАЛТ ХИЙСЭН ТАЙЛАН. 2021.11.02

Хяналтыг 2021.11.02-ны өдөр сумын Иргэдийн хурлын дарга Т.Батжаргал, тэргүүлэгч буюу СХС-ийн ОТБХЗ-ийн дарга Ж.Мөнхтөр, сумын Засаг дарга С.Бат-Оргил нарын хамт газар дээр очиж үзлээ.

2021 онд Сайнцагаан сумын “Сум хөгжүүлэх сан”-аас зээл авч төсөл хэрэгжүүлж байгаа Зээлдэгчийн үйл ажиллагаатай танилцлаа.

1. “Оёдол”-ын “Ажлын байр барих” М.Оюун-Эрдэний төслийн явцтай танилцлаа. Төслийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, ажлын байраа 100 хувь ашиглалтад оруулж амжилттай хэрэгжүүлж байна. Ажлын бүтээмж дээшлэн иргэдийн захиалга тасрахгүй байгаа талаар төсөл хэрэгжүүлэгч маань сэтгэл хангалуун ярьж байлаа.



2. “Нимгэн төмөр эдлэл”-ийн “Ажлын байр барих” Ц.Пүрэвсүрэнгийн төслийн явцтай танилцлаа. Төслийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж ажлын байраа барьсан төмөрчин ах маань улирал харгалзахгүй ажлаа хийх болсондоо баяртай байгаагаа илэрхийллээ.



3. “Хүнсний ногооны зоорь барих” зориулалтаар зээл авсан А.Оюунтунгалагийн төслийн явцтай танилцлаа. Өөрийн болон төслийн хөрөнгө оруулалтаар Зоорины заслаас бусад ажлыг 100 хувь гүйцэтгэж 70 тн төмс, хүнсний ногоог нөөцөлсөн байна. Энэхүү төсөл хэрэгжснээрээ хүнсний ногооны үнийн хөөрөгдлийг бууруулах, орон нутгийг монгол ногоогоор хангах зорилготой. Төслөө амжилттай хэрэгжүүлж байгаа А.Оюунтунгалагийн бизнест нь удирдлагууд амжилт хүсч, хүнсний ногооны нөөцийг бүрдүүлж ажиллахыг зөвлөлөө.



4. Сайнцгаан сумын “Сүм хөгжүүлэх сан”-аас “Тахианы аж ахуй”-н зориулалтаар зээл авсан “Жаргалант сор” ХХК-ны төслийн явцтай сумын ИТХ-ын дарга Т.Батжаргал, Засаг дарга С.Бат-Оргил нар танилцлаа. Тахианы байр барих, гадна дотор тохижилтын ажлыг 100 хувь гүйцэтгэж, дэгдээхэйгээ хүлээн авхад бэлэн болсон байна. Энэхүү төсөл хэрэгжсэнээр аймгийн хэмжээний өндөгний

зах зээлийг бүрэн хангаж 4-5 байнгын ажлын байр бий болох юм. Төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлж байгаа “Жаргалант сор” ХХК-ны захирал Ж.Рэнцэндавгад сумын удирдлагууд амжилт хүслээ. 2021,10,17





САЙНЦАГААН СУМЫН “СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН”-ИЙН 2021 ОНД ОЛГОГДСОН ЗЭЭЛИЙН ЯВЦАД ХЯНАЛТ ХИЙСЭН ТАЙЛАН. 2021.07.08





Хяналтыг 2021.07.08-ны өдөр сумын Иргэдийн хурлын дарга Т.Батжаргал, төлөөлөгч Ц.Цогзолмаа, А.Отгонбаатар ЗДТГ-ын ЖДҮГТ хариуцсан мэргэжилтэн Ш.Бямба нарын хамт газар дээр очиж үзлээ.

Явцын хяналтыг хүснэгтээр харуулбал:

№	Төсөл хэрэгжүүлэгч иргэн хуулийн этгээдийн нэр	Олгосон мөнгөн дүн /сая/	Зээлийн эргэн төлөлт	Зориулалт	Зураг тайлбар

1	Улаанбаатар.Х	30	Хэвийн	Чулуун урлал	 <p>төсөлд тусгагдсан чулуу зүсэгч, цоологч, өнгөлөгч, сийлбэрийн зэрэг 5 машиныг шинээр авч түүхий эд материалаа татан авсан үйл багаж, тоног төхөөрмөжөө арай угсарч амжаагүй байлаа.</p>
2	Оюун-Эрдэнэ.М	6	Хэвийн	Ажлын байр барих	 <p>ажлын байраа барьж төслөө 100 хувь хэрэгжүүлсэн байлаа.</p>
3	Намнансүрэн.М	5	Хэвийн	Хүнсний ногооны тариалалт	 <p>32 мк хүлэмжид 3 төрлийн ногоо тарьж төслөө хэрэгжүүлсэн.</p>

4	Энхбаатар.Ц	25	Хэвийн	хүлэмжийн аж ахуй	 <p>Цэвэр ус татаж 96 мкв хүлэмжийг өөрсдөө барьж 4 төрлийн нарийн ногоо, 3 төрлийн хүнсний ногоо 12 мкв талбайд тариалсан. Ковидын улмаас үйлдвэрийн хүлэмжээ татан авч чадаагүй байгаа.</p>
5	Өнөд ширээт ХХК	30	Хэвийн	арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	 <p>Хос оёдлын машин,авч түүхий эдээ татан авч 12 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 1800,0 төгрөгийн борлуулалт хийсэн.төслийн хэрэгжилтийн явц сайн.</p>

6	Пүрэвсүрэн.Ц	20	Хэвийн	Нимгэн төмөр эдлэлийн ажлын байр барих	 <p>ажлын байр материал, /мод, сайтинга,цемент/ түүхий эд /нимгэн хар, цагаан төмөр/-ээ татсан. Ажлын байраа барьж эхлээгүй байлаа. 9 сарын 2-ны дотор буюу гэрээний хугацаандаа барьж дуусгах боломжтой.</p>
7	Тогтох мандал ХХК	50	Хэвийн	Махны бөөний болон жижиглэн худалдаа	   <p>Дотор хөргүүрүүд, вакумын машинаа бэлдсэн. Гадаа зоорь бэлэн болсон. Захаа хойд тал руу нь өргөтгөөд махны жижиглэн худалдаагаа 8 нэрийн барааны дэлгүүртэй хамтатган үйл ажиллагааг явуулна.</p>
8	Олдох гурван эрдэнэ ХХК	50	Хэвийн	Мах савлах	Төсөл тусгагдсан бүх тоног төхөөрөмжөө БНХАУ-руу захисан каргогоор ирнэ. Одоогоор үйл ажиллагаа эхлээгүй байна.

9

Говийн гэгээ
ХХК

83

Хэвийн

ТАЛХ
НАРИЙН
БООВНЫ
ҮЙЛДВЭРЛЭЛ
, ҮЙЛЧИЛГЭЭ



Төслөөр авах тоног төхөөрөмж, түүхий эд, сав баглаа боодол, түгээлтийн машинаа авсан. Үйлдвэрлэлийн байрны засвараа одоо хийнэ.

Төслөөр авах тоног төхөөрөмж, түүхий эд, сав

10	Дэлгэрмаа.Г	30	Хэвийн	<p>ГАЗАР ТАРИАЛАН</p>	<p>240 мкв талбайд 4 төрлийн нарийн ногоо, 1 га талбайд 4 төрлийн хүсний ногоо, төмстэй тариалсан. Хадуур усалгааны системээ авсан. Төслөөр авах зүйлүүдээ 100 хувь авсан. Төслийн хэрэгжилт сайн.</p> 
11	Оюунтунгалаг.А	30	Хэвийн Хэвийн	<p>хүнсний ногооны зоорь барих</p>	 <p>80 тн-ын багтаамжтай хүнсний ногооны зоорь ид бүтээн байгуулалтын шатандаа явж байлаа. Төслийн хэрэгжилт сайн. Гэрээний хугацаандаа зоорио барьж дуусгах боломжтой.</p>

	12 Жаргалант сop ХХК				 <p>Өөрийн хөрөнгөөр тахианы байрныхаа кундомыг тавиад эхэлсэн, барилгын материалуудаа татан авч гэрэл цахилгаандаа холбогдсон. Өөрийн хөрөнгөөр хийгдэх ажлынхаа эхлэлийг сайн тавьж байгаа гэж дүгнэсэн.</p>
	Дүн	359.2			

ХЯНАЛТЫН ЯВЦЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

ЗДТГ-ЫН ЖДҮГТХ МЭРГЭЖИЛТЭН Ш.БЯМБА

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

II УЛИРАЛЫН ХЯНАЛТЫН ХЭРЭГЖИЛТ 2021.07.05

№	Зээл олгоон үйл ажиллагааны чиглэл, иргэн, ААН-ийн нэр	Нийт олгосон зээлийн тоо	Зээл олгоход бүрдүүлэх баримт бичгийн бүрдэл	Олгосон зээлийн хэмжээ /хүссэн зээлийн хэмжээ, дэмжигдсэн зээлийн хэмжээ/	Эргэн төлөлт, хугацаа хэтрэлт	Илэрсэн зөрчил, дутагдал /зориулалтаар явагдаж буй эсэх/	Авсан арга хэмжээ
1	<ul style="list-style-type: none"> ➤ Хүнсний чиглэлээр-3 /талх нарийн боов, мах савлах, боловсруулах ➤ Газар тариаланд -4 /зоорь барих, төмс, хүнсний ногоо хүлэмжийн аж ахуй/ ➤ Хөнгөн үйлдвэрлэлийн -4 /арьсан эдлэл, нимгэн төмөр, чулуун урлал, оёдол үйлдвэрлэл/ 	11	Журмын 4,8-д заасны дагуу баримт материалаа бүрдүүлж авсан	25 зээлдэгчээс 920 сая төгрөгийн төслийн хүсэлтийг хүлээн авч судлан, хэлэлцэж 5 ААН, 7 иргэнд 459,2 сая төгрөгийн төсөлд зээл олгохоор дэмжиж өнөөгийн байдлаар 4 ААН, 7 иргэнд 359,2 сая төгрөгийн зээлийг 2021.05.19-06.16-ны хооронд олгоод байна.	6,7 дугаар сарын төлөлтүүд 100 хувь хийгдсэн. Хугацаа хэтрэлт одоогоор гараагүй байна.		

ХЭРЭГЖИЛТИЙГ ТООЦСОН:

ЗДТГ-ЫН ЖДҮГТХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.БЯМБА